

Хичээл №3

БҮТЭЭЛЧ СЭТГЭЛГЭЭГ ХӨГЖҮҮЛЭХ АРГА, ТЕХНОЛОГИ Агуулга

- I. Технологи ба бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх арга?
- II. Эргэн санах
- III. Бүтээлч сэтгэлгээг идэвхжүүлж, хөгжүүлэх боломжууд
- IV. Жишээ дасгалууд
- V. Даалгавар

I. ТЕХНОЛОГИ БА БҮТЭЭЛЧ СЭТГЭЛГЭЭГ ХӨГЖҮҮЛЭХ АРГА?

Өнөөдөр бидний бараг алхам тутамдаа хэрэглэж байгаа “Технологи” гэдэг үг нь эртний грекийн **τέχνη** (téchni – чадвар, урлах, хийх) + **λόγος** (lógos – үг, сэтгэхүй, оюун, өгүүлбэр, хэлэх, зүй тогтол, утга санаа, учир шалтгаан) гэсэн хоёр үгнээс гаралтай нэр томъёо - ойлголт юм байна:

Хамгийн түгээмэл утгаараа бол технологи нь өмнөө тавьсан зорилгодоо хүрэхийн тулд ашиглах арга хэрэгсэл, ажил үйлдэл, тэдгээрийн дэс дараа, горимыг тогтоосон заавар гэсэн утгаар ойлгогддог.

Эхлээд аж үйлдвэр, шинжлэх ухааны салбарт ихэвчлэн хэрэглэгдэж байснаа яваандаа соёл урлаг, нийгэм улстөр, хүмүүнлигийн салбарт ч өргөн хэрэглэгдэх болсон. Жишээлбэл: үйлдвэрийн технологи, өндөр технологи (микроэлектроник, сансар, биотехнологи, нанотехнологи...), тоонтехнологи, барилгын технологи, нийтийн хоолны технологи, дизайн-технологи, сонгуулийн технологи гээд үргэлжлээд их өргөн хүрээнд хүртээмжтэй хэрэглэгдэх болсон үг.

Бүтээлч сэтгэлгээ, бүтээлч үйлсэд ч гэсэн өөрийн гэсэн өвөрмөц арга барил, тодорхой дэс дараатай үйлдлүүдийг гүйцэтгэж дадвал богино хугацаанд сэтгэлгээгээ хөгжүүлж, үр дүнд хүрэх боломжтой. Тэгэхээр бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх арга технологи гэж хэлж, ярьж болох нээ!

Тэгвэл, бүтээлч сэтгэлгээний технологи буюу тэр дэс дараатай үйлдэл-үе шатууд, тэдгээрийн хоорондын уялдаа холбоо болон сэтгэлгээгээ бүтээлч тал руу хөгжүүлэх олон арга технологи байдгийн заримтай нь танилцаад, бусадтай нь та бүхэн маань бие даан танилцаж хувь хүнийхээ хөгжилд ашиглах бүрэн бололцоотой шүү !

II. ЭРГЭН САНАХ

Бүтээлч үйл ажиллагааны үндсэн үе шатууд

хувилбартай асуултууд гаргаж эрэл хайгуул хийнэ. Ухаандаа “утас-хулгана” гэхээр компьютерийн хулгана гэсэн нэг гаргалгаа байж болно. Бас бүр эсэргээрээ хулгана цахилгааны утсыг мэрээд богино холбоос үүсэж гэрийн ток тасрах, магадгүй түймэр гарч гал команд ирж ч болох юм. Тэр гайхал хулгана утсаар дамжин зүүлттэй байгаа борцноос хулгайлж ч мэднэ гэх мэт бодомжийн хувилбарууд зохиох зэргээр ажиллах хэрэгтэй л дээ.

Тонгоруулсан үг – ганцаараа байхдаа ч юмуу, гэртээ хүүхдүүдтэйгээ байхдаа, найзууд хоорондоо тоглоом хэлбэрээр хийж болох дасгал. Бас автобусанд явж байхдаа ч реклам, сурталчилгааны үгсийг тонгоруулан уншиж болно.

Латерал сэтгэлгээ. (Lateral-хөндлөнгийн, хажуугийн, салаа). Юмс үзэгдлийг олон талаас нь харж тайлбарлах, салаа утга, түүнчлэн асуудлаа гаргах стандарт бус шийдэл олох, санаандгүй бүтээгдэхүүн, хэрэглээ бодож олох чадвар.



Шүхэр: шүхрийн үндсэн хэрэглээ бол борооноос ч бас нарнаас ч хамгаалахад зориулагдсан. Тэгвэл өөр ямар хэрэглээ байж болох вэ? Төмхөн шүхрийг бүтээлгээр хучаад байрандаа майхан босгоод хүүхдүүдээ тоглуулж болно, хуучирч эвдэрсэн хар шүхрээр сарьсан багваахайн далавч урлаад багт наавамд орж болно... гэх мэт. Биднийг бага байхад ээжүүд хуучирч эвдэрсэн шүхрийн материалаар уут сав хийгээд, дэлгүүрээс хүнсээ цуглуулахдаа барьж явдаг байсан.

Зургаан малгай. Бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх нэлээд сонирхолтой арга. Харин үүний тулд 6 хүн хэрэгтэй болно. Багаар ажиллана гэсэн үг. Асуудлыг шүүн хэлэлцэх, хариу шийдэл олох явцад хүн бүр өнгө өнгийн малгай өмсөөд өөр өөрийн үүрэг гүйцэтгэнэ.

Цагаан малгайт – логик сэтгэлгээг хариуцана. Цагаан малгайт бол бүх зүйлийг дүрэм, журмын дагуу, учир шалтгааны уялдаа холбоотой нь авч үзэх үүрэгтэй, ёстой “онолын номч” хүн.

Шар малгайт – бодлого, асуудлыг эерэг талаас нь харж, зөвхөн сайн, давуутай чанаруудыг тодорхойлогч оптимист – өөдрөг үзэлтэн

Хар малгайт – бусдын саналын бульхайг илрүүлж “будaa” болгох (илчлэх) үүрэгтэй шүүмжлэгч - пессимист.

Ногоон малгайт – төрөл бүрийн олон санаа гаргаж шийдэл хайгч “санаачлагч генератор”.

Улаан малгайт – асуудлаа ярилцан даалгавар гүйцэтгэж байх үед өөрт төрж буй сэтгэл хөдлөл-эмоцоо илэрхийлэх үүрэгтэй нэгэн.

Хөх малгайт – Бусдынхаа санаа бодол, санаачлагыг нэгтгэн цэгцлэх үүрэгтэй “газар үзэж нүд тайлсан” философич

Тархины дайралт – асуудлыг шийдэж бодлогыг бодох байж л болох хамгийн боломжит, хамгийн олон саналуудыг ямар ч цензургүйгээр оролцогчид дэвшүүлнэ. Хэлэлцүүлгийн явцад бүх хувилбарыг шүүн тунгаагаад шилдгүүдийг нь сонгоод цаашид дахин боловсруулна.

Мөн үүний эсрэг “**сөрөг тархины дайралт**” хийх нь гэнэтийн сонирхолтой санаа шийдэлд хүргэх нь олонтаа. Өөрөөр хэлбэл асуудлыг шийдэх ямар ч боломжгүй, харин ч байдлыг улам хүндрүүлсэн тийм алдаатай, буруу саналуудыг дэвшүүлж хэлэлцэнэ гэсэн үг. Энэ аргаар асуудлын далд утга учир ил гарч ирэх нь бий. Гол ач тустай зарчим нь “асуудлын шалтгааныг бариад авбал оновчтой шийдэл ойрхон” гэсэн үг л дээ. Үүнийг хийж үзэхэд илүүдэхгүй!


Интеллект карт – Богино хугацаанд сайн үр дүн гаргах аргуудын нэг. Хуудас цаасны голд шийдэх гэж байгаа асуудал, бодох бодлогоо бичнэ, эсвэл зурна (өөрийн эсвэл багийнхныхаа зургийг байрлуулж болно). Түүнээсээ тал бүр тийш нь салаа мөчир үүсгэн шийдэлд хүргэж болох гэмээр санаанд орсон сэтгэгдэл, төрсөн бодлуудаа бичнэ. Тэдгээр нь цаашид бас салаалж болох юм. Богино хугацаанд сайн үр дүн гаргах аргуудын нэг.

Урлаг бясалгал – уран зураг, хөгжим дуу, утга зохиол зэрэг урлаг соёлын бүтээлүүд нэг талаас бүтээлч хүний сэтгэл санааг амраан алжаалыг тайлж, нөгөө талаас оюун ухааныг урам зориг, онгод хиймориор цэнэглэн, бүтээх туурвих их эрч хүч өгдөгийг бид бүгд өөрсдийн урлан бүтээх үйлээсээ биеэрээ мэдэрдэг.

Мөн алдрай бяцхан үрс, ач зээ нар маань хөгжилтэй хөгжмийг даган дуулж бүжиглэн хөгжин баясаж байхад азай буурлууд маань уртын дуугаа сонсохдоо уужуу тайван, сэтгэл тэнүүн байдаг шүү дээ.

Тэгсэн мөртлөө ажил төрөл, ахуй амьдралдаа “дарагдсан” бид тэр бүрийг анзаарах ч сөхөөгүй зүтгэсээр, зүдэрсээр явдаг тал бий. Заримдаа түр ч гэсэн хамаг проблемыг тас хаяад байгалийн тансаг сайхан, урлагийн гайхамшигт бүтээлийн орчинд уусан чөлөөтэй амарч хүчээ сэлбэх маш чухал. Үүнийг бүтээлч хүмүүс сайн мэдэж, ашиглаж байдаг. Тиймдээ л тэд чинь бүтээлчид байдаг. Нэг чухал жишээг эргэн санья л даа.

XX зууны эхэн үеийн Мексикийн алдарт зураач эмэгтэй Фрида Кало осолд ороод хэвтэрт орчихоод байхдаа урлагаас эрч хүчээ сэлбэн туурвисан бүтээлүүд нь хамгийн үнэ цэнтэй бүтээлүүд байсан. Өмнө нь тэр анагаахын мэргэжилтэй эмч хүн байжээ.



Фрида Калогийн өөрийн хөрөг



**Фрида Кало хэвтэрт орчихоод байхдаа.
Урлаг түүнд тэвчээр, хүч, бүтээлч чанар өгчээ.**



Хэвтэрт байхдаа бүтээсэн зургуудынн нь нэг. Тэрээр эмч байсан тул дотоод эрхэтнүүдээ ч дүрсэлжээ.

Эндээс бид бүтээлч хүний тэвчээр, урам зориг, тайван амгалан уян хатан чанар, хамгийн гол нь дотоод эрч хүчээ дайчлан өөрийгөө удирдах, бясалгагч онцлог мөн чанаруудыг олж харж, бахархаж, өөрсдийн байдалтай харьцуулж, сэдэл тэмүүлэлээ эрчимжүүлж болмоор санагдана.

IV. ЖИШЭЭ ДАСГАЛУУД

Үгэн тоглоом. Үг хэллэг, нэр томъёо ашигласан дасгал наадам бүтээлч сэтгэлгээ хөгжүүлэх сайн хэрэгсэл байдаг. Жишээ нь: 1. Цэцэг гэдэг үгийг тодорхойлсон аль болох олон **нэр үг** олох – ургамал, ногоо, дэлбээ, цомирлог, бал, үзэмж гоо, иш навч г.м. 2. Уялдаа холбоо бүхий үгсийн жагсаалт зохиох: дээвэр гэдэг үгнээс жагсаалт зохиовол – байшин, гэр, хана, хаалга, цонх, шал, тааз, туурга, эсгий, хөвөн, оосор, бүч, тэнгэр г.м. 3. Дурын нэг үсэг аваад түүгээр эхэлсэн аль болох олон үг зохиох.

Ижил төстэй шинж чанаруудыг олох. Огт хамааралгүй зүйлсийн ойролцоо чанаруудыг олж илрүүлэх. Машин – бөмбөг, ус – элс, онгоц – далай, мод – нохой гэсэн хос үгсийн ижил төстэй талуудыг нэрлэнэ гэсэн үг.

Таамаглал. Төсөөлөн бодож, дүрслэн зураглах сайн дасгал. Жишээ нь: гэнэт динозаврууд эргээд ирвэл юу болох вэ? Таван хошуу мал маань таны хэлээр яриад эхэлбэл яах бол? Маргааш бид бүгд нисдэг болчихвол? г.м.

Юмсын шинжийг тодорхойлох. Харж буй алив зүйлсийн шинж чанарыг илэрхийлсэн тэмдэг нэрсийг тоочих, тэгээд дараа нь огт нийцэхгүй шинжүүдийг бас тоочих. Ж нь, ширээн дээр байгаа ваарыг авъя – шавар, галуун хүзүүт, хятад, будаатай г.м. эсрэг нь – зөөлөн, шингэн, цаасан, торон гэх мэт байж болох юм.

Та бид одоо нэгэнт магистр, докторын түвшинд хүрчээд иймэрхүү энгийн жишээгээр бүтээлч сэтгэлгээгээ хөгжүүлэх тухай яриад сууж байгаа маань баахан хожуу ч юм шиг, бас гунигтай эсвэл уйтгартай ч юм уу санагдаж магадгүй, гэвч сурахад, хөгжиж дэвшихэд хэзээ ч оройтохгүй, бас аливаа нэг энгийн зүйлд хамгийн эрхэм, гоц чанар хадгалагдаж байдаг гэдгийг нэг эрэгцүүлж үзээрэй. Мөн эдгээр энгийн мөрглөө ач тус ихтэй дасгал тоглоомуудыг хүүхдүүдтэйгээ хийж байвал тэднээс томчуудаас ч илүү бүтээлч, чөлөөтэй, сонин содон, **хамгийн хамгийн** санаанууд гарах тул танд энэ бүхэн нээрээ л хамгийн чухал үр өгөөжтэй арга технологи болох нь амархан ойлгогдох вий!

Ер нь бүтээлч хүмүүс өндөр нас насалж өв тэгш аз жаргалтай амьдардаг гэсэн судалгааны үр дүн ч бас байдаг шүү! Энд би Стив Жобсын тухай яриагүй шүү. Хэнд ч, хэзээ ч давшгүй хүчин зүйлс тохиолдож болно. Үүнийг таашгүй, ёстой нөгөө үйлийн үр ч байж мэдэх шүү дээ!

Сонирхолтой нь бурханы шашинтангууд маань сүсэг бишрэл, итгэл үнэмшил дээрээ тулгуурлаад сансар огторгуй, хорвоо дэлхий, бүх ертөнцийн “шүтэн барилдлага”, “хоосон чанар”-ыг танин барих, шүтэх тухай ярьж, сургаалиа айлдаж

байна. Мөн тэд тархи судлалыг ч бас аль эртнээс судлаад, сургааль номоороо дажуулаад өвлүүлсэн байдаг. Орчин үеийн нэрд гарсан сэтгэл судлаач, сэтгэгчдийн дэвшүүлсэн онолууд Буддизмын философитой тохирч байх¹ жишээтэй. Харин, бидний шүтээн болсон шинжлэх ухаан маань нүдэнд харагдаж, гарт баригдах баримтыг л хүлээн зөвшөөрөх жишээтэй. Уг нь шашин, шинжлэх ухаан хоёр маань “Арга–Билэг” болж нэгдээд аз жаргалыг бүтээж болмоор санагдах юм. Та бүхэн бас бодоорой!

Бага насны хүүхэд бидний бүтээлч сэтгэлгээний багш:

Хүүхэд томчуудаас илүү бүтээлчээр чөлөөтэй сэтгэдэг. Хүүхдүүдтэйгээ хамтарч бүтээлч сэтгэлгээгээ хөгжүүлэх нь юу юунаас ч илүү ач тустай. Та бүхэн ч энэ тал дээр надтай санал нэгдэх байх.

Бүтээлч сэтгэлгээ, бүтээлч үйлсийн талаар бодож, судалж явахад надад нэг чухал санаа төрөв. Юу гэхээр, бидний хүүхдүүд, ач зээ нар маань байна шүү дээ! Бүтээлч, шинэлэг, гайхалтай санаа, аливааг эргэцүүлэн шүүн тунгааж бодож үзэх хэрэгтэй зүйлсийг тэд маань бидэнд бэлнээр нь өгч байх мэт санагддаг. Харин тэдэнтэйгээ бид тоглож наадаж, эн чацуу ярилцаж байна уу? Тэгвэл, тэд бидэнд мөн ч их санаа оноо өгдөг шиг санагдана. Тэр бүхэн нь бас л бидний бүтээлч сэтгэлгээнд ач тустай. Жишээлбэл, манай ач хүү Б.Тэмүүлэн, 1-р ангид сурч байхдаа “С” үсгийг эсрэг тал руу нь харуулж “Э” бичдэг байлаа. “Миний хүү буруу харуулаад бичээд байна, засаарай” гэхэд “Үгүй ээ, би “С” үсэг ямар байдгийг мэднэ, ном уншихдаа зөв уншиж чадаж байгаа. Би тэгэж бичмээргүй байна. “Э” ингэж бичих нь надад гоё байдаг. Тийм байгаа биз дээ?” гэж зөрүүдэлдэг байлаа. Ач хүүгийн маань дүү охин одоо 2-р ангийг сурагч Б.Есүйжин, бас л ах шигээ сонирхолтой зан гаргана. Бичихдээ зориудаар хэт том, хэт жижиг үсэг хольж бичнэ. Цэвэр сайхан жигд бичихийг шаардахаар бас л энэ нь гоё, яагаад зэвал наймайг ижил бич гээд байгаа юм бэ? зөв л бичвэл болно. Өндөр, нам бичвэл илүү гоё байгаа биз дээ, Хар даа! өөрөө мэдээд бичвэл л гоё болно! гэж зөрүүдэлдэг.

Яг иймэрхүү нөхцөл байдалд бид илүү нухацтай хандах хэрэгтэй юм шиг санагддаг. Тэгээгүйгээс болж, өөрөөр хэлбэл бид заавал өөрсдийн санааг тулган шаардсанаас болж хүүхдүүдийн бодол, сэтгэлгээ хайрцаглагдаж, эвдэрч эхэлдэг байна. Иймэрхүү бидний хайхрамжгүй ханддаг жишээ бүх л гэр бүлд тоолж баршгүй олноороо байгаа нь мэдээж. Эндээс л эхлээд бид үр хүүхэд, залуу хойч үеийнхнээ баллаад байгаа шүү дээ!


¹ Юнг К.Г. Бэлгэдэлт амьдрал.- УБ., 2011.- Х.375-392.

Хүн бага насны унаган чөлөөт сэтгэлгээний чадвараа нас бие гүйцэх тусам хуримтлуулсан мэдлэг, туршлага, логик бодлуудаараа баглаад, хайрцагнаас гадуур буюу чөлөөтэй сэтгэх бололцоогоо алддаг гэдэг шүү дээ. Үүн дээр бид олон талаас нь шүүн тунгааж, хүүхдийн унаган чадварыг нь аль болохоор хэвээр нь үлдээх хөтөлбөртэй баймаар!

Мөн хүүхдүүдийн зохион хэрэглэдэг үгс тэдний бүтээлч, чөлөөт сэтгэлгээг тод илэрхийлж байдаг. Жишээлбэл, миний ахын ууган ач охин Нинжин хэлд орохоосоо л талхыг “БАМУУ” гэж нэрлэсэн. Дүү нар нь дагасан. Одоо хэр нь гэртээ бамуу, харин дэлгүүрт бол талх гэж нэрлэж байна. Ер нь яагаад байж болохгүй гэж? Талхыг ер нь хэн, хэзээ талх гэж нэрлэсэн юм бол? Тэгвэл, манай хүүхдүүд өөрийнхөөрөө оригинал нэр өгчээ.

Аав ээж нь, эмээ өвөө нь хүүхдүүдтэйгээ найзалбал өтөл нь эрүүлжин залуужиж, балчир нь өсөж торнино, жинхэнэ утгаараа ёстой нөгөө аз жаргалтай БҮТЭЭЛЧ амьдрал хялбархан цогцолно биз дээ!

Тэднээс маань ийм л бидний зүүдэнд ч оромгүй зүйлс зөндөө гарна. Та нар ч гэсэн өөрсдийн бяцхан дүү нар, хүүхдүүдийнхээ энэ мэт сонин содон үг хэл, нэршилгээ, үйлдлийг сайн ажиглаж, шүүн тунгааж үзэхэд санаа авах, ургуулан бодох олон янзын бодол санаа төрөх төдийгүй уран бүтээлийн санаа сэдэл, зохиол бүтээл ч төрөн гарах өргөн боломжтойг санаарай!



Миний бодлоор хүүхдүүд маань ер нь аав ээжээсээ авсан, өвөг дээдсээсээ өвлөсөн аз жаргалынхаа замаар явах гэж тэмүүлдэг байх. Харин бид – томчууд түүнд нь тээг саад болоод байгаа юм биш биз?

Хамгийн бүтээлч сэтгэлгээтэй, хязгааргүй зөгнөл, мөрөөдөлтэй үе бол хүүхэд нас. Тиймээс хүүхдүүдтэйгээ “хамтарвал” аль алинд нь ашигтай, дэндүү ашигтай гэмээр

байна. Тэд бол санаандгүйгээр бүтээлч, ёстой “галзуу” санаанууд гаргадаг “генераторууд” гэдгийг байнга санаж байх нь чухал!



За ингээд хүүхдүүдтэй маань холбоотой хувийнхаа хэдэн санааг хуваалцъя!

Бүтээлч гэр бүл байх нь чухал:

Хүүхдүүдийнхээ дуртай, сонирхдог зүйлийг хамтарч хийх, тоглох, хамтдаа баярлах гэх мэтээр тэдэнтэйгээ хамт байх цаг мөчийг аль болох бүрдүүлэхийг хичээж, анхаарах хэрэгтэй. Жишээлбэл, Халловиний баяр гэх мэт... олон бий.

Хүүхдүүдтэйгээ ажиллахдаа анхаарах нь:

1. Тэднийгээ фантаазалж байхад нь хэзээ ч бүү шүүмжил! Харин ч хүү нь “хорон санаатныг яаж хөнөөсөн, хамуутай даага нь яаж хурдалсныг нь асууж хөгжөө,
2. Хамтдаа чулуугаар тоглож, гэр барьж, зочдоо дайлахдаа сургаалыг үгс, оньсого таавар ашиглавал бүр сайн,
3. Яг хэрэгтэй тоглоомууд, харандаа будаг, баримлын шавар, лега конструктор бэлэн байлга. Гэхдээ өөрт нь онцын сонирхолгүй илүү олон тоглоом хэрэггүй,

Эцэст нь дараах хэдэн зөвлөмжүүд байна:


1. Хамгийн энгийн зүйлсийг аваад олон янзын хэрэглээ бодож ол. Жишээлбэл, Ширээг юунд, яаж хэрэглэж болмоор байна!
2. Хэдхэн үгийн дотор жижиг түүх, зөгнөлт өгүүллэг зохиож үз. Зөгнөл, фантаазаа зөнгөөр нь тавиад чөлөөтэй сэтгэ!
3. Шинэ ном авбал дундаас нь, бүр төгсгөлөөс нь уншаад үз. Эхлээд тайлалтай нь танилцаад, өрнөлийг нь дараа нь уншихад сонирхолтой санаанууд гарна!
4. Бас үлгэр ч юм уу, сонирхолтой ном уншиж өгөхдөө төгсгөлийг нь уншиж өгөлгүй өөрсдөөр нь зохиолгож дуусгуулах бас нэг арга бий. Эндээс таны

бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх, идэвхижүүлэх мэргэн санаа ч бас гарч ирэх магадлал бий шүү!

5. Өөрсдөөр нь үлгэр, ном зохиолгох бололцоотой зарим санаанууд байна.
6. Ижил төстэй, эсвэл эсрэг утгатай үг хэллэг хэрэглэж бай. Яриа чинь баяжиж, сэтгэлгээ тань тэлнэ. Сайн сайхан, тэсхим хүйтэн, халуун цас, муусайн... гэх мэтээр!
7. Мэдлэг, мэдээллийнхээ хүрээг тэлж бай. Хөдөө орон нутгаараа аялаж үндэстэн угсаатнуудынхаа өв уламжлалтай танилцаж, хангай дэлхийнхээ тансаг сайхныг мэдэрч, баясан цэнгэж бай. Харин интернет, хэвлэлийн хогоор толгойгоо бүү дүүргээрэй. Хар бараан мэдээлэлээс аль болох хол, чөлөөтэй бай!

ДААЛГАВАР

1. Бага насны хүүхдүүдийг ажиглан тэдний өөрсдийнхөөрөө чөлөөтэй сэтгэж, үйлдэж байгаа хэл яриа, үйл хөдлөлийг тэмдэглэн авч судалгаа, уран бүтээлийн эх үүсвэр болгон ашиглах санаа, зөвлөмж гаргаж семинарийн хичээлээр сэдэв болгон ярилцах! (*Хүн тус бүрээр гүйцэтгэнэ*)
2. “Зургаан малгай” тоглоомын зарчмыг ашиглан 1-р хичээлийн эхний даалгаварыг гүйцэтгэж эхлэх!



АМЖИЛТ ХҮСЬЕ!

АНХААРАЛ ТАВЬСАНД БАЯРЛАЛАА!